



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 636

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасч,
залруулга хийх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, нийт 12,294,806.55 (арван хоёр сая хоёр зуун ерэн дөрвөн мянга найман зуун зургаан төгрөг тавин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасч, залруулахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын ерөнхий захирал А.Эрдэнэтуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

123006675

32-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023оны // дүгээр сарын 3-ны ний өдрийн
.....636 дугаар тогтоолын хавсралт

ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХОЁРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр төрөл	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Мөсөн ханатай хөргөгч	2021	2	4,789,307.56	9,578,615.12
2	Хөргөгч	2021	1	2,716,191.43	2,716,191.43
НИЙТ ДҮН			3		12,294,806.55 (арван хоёр сая хоёр зуун ерэн дөрвөн мянга найман зуун зургаан төгрөг тавин таван мөнгө)